

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА  
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

**БУЯНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2020 ОНЫ ЖИЛИЙН  
ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

Аудитын код: ХОА-2021/151/СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a></p> <p>Ховд хот 2021 он</p>	<p>Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар Утас: 70433061 Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn Аудитын менежер: А.Цэцэгсүрэн Утас:70432545 Цахим хаяг: Tsetsegsuren.A@audit.gov.mn Аудитор: Д.Балжинням Утас: 70432545 цахим хаяг: Baljinnyam.d@audit.gov.mn</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Товчилсон үгийн жагсаалт**

<b>АДБОУС</b>	<i>Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт</i>
<b>АОУС</b>	<i>Аудитын Олон Улсын Стандарт</i>
<b>УСНББОУС</b>	<i>Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт</i>
<b>ТТЗ</b>	<i>Төсвийн төвлөрүүлэн захирагч</i>
<b>ТШЗ</b>	<i>Төсвийн шууд захирагч</i>
<b>ТБОНӨХБАҮХАТ</b>	<i>Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай</i>
<b>ЗДТГ</b>	<i>Засаг даргын дамгын газар</i>
<b>ОНХС</b>	<i>Орон нутгийн хөгжлийн сан</i>
<b>ИТХ</b>	<i>Иргэдийн Төлөөлөгчдийн хурал</i>
<b>ЗД</b>	<i>Засаг дарга</i>

## Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт .....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	8
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан .....	9
3. Аудитын тайлан.....	10
3.1. Ерөнхий зүйл.....	10
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	10
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт .....	10
3.4. Материаллаг байдал .....	11
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	11
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт .....	12
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	13
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	13
3.9. Аудитын илрүүлэлт.....	13
Залруулсан алдаа.....	13
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил ..	<b>Error! Bookmark not defined.</b>
Аудитын зөвлөмж.....	14
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд .....	14
4. Менежментийн захидал.....	15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт .....	16

## 1.ТӨРИЙН АУДИТЫН САНАЛ, ДҮГНЭЛТ

---

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### 2.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН /төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>18,016,709.00</u></b>	<b><u>17,507,303.00</u></b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	572,609.00	301,263.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага		301,263.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	17,444,100.00	17,206,040.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	16,444,100.00	17,206,040.00
35410	Бичиг хэргийн материал	1,215,800.00	1,218,600.00
35420	Аж ахуйн материал	9,822,200.00	10,346,400.00
35440	Түлш, шатах тослох материал	3,562,100.00	3,797,040.00
35450	Барилгын засварын материал	455,000.00	455,000.00
35470	Бусад хангамжийн материал	1,389,000.00	1,389,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>1,277,154,665.17</u></b>	<b><u>1,639,593,715.25</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	1,277,154,665.17	1,639,593,715.25
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	929,609,390.15	1,292,362,690.35
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,166,151,516.64	1,234,436,594.64
39202	Хуримтлагдсан элэгдэл	(376,615,723.10)	(441,624,030.74)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	131,899,950.00	111,909,950.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(84,635,714.16)	(79,197,489.80)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	71,336,247.00	75,618,247.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(63,733,207.28)	(66,070,712.32)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	51,290,000.00	54,575,000.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(30,906,780.95)	(34,191,126.43)
39209	Зам, гүүрийн байгууламж	64,823,102.00	370,638,098.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	-	(3,661,840.00)
39216	Дуусаагүй барилга, байгууламж		69,930,000.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	347,545,275.02	347,231,024.90
39301	Програм хангамж	3,117,000.00	3,117,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,917,124.98)	(2,231,375.10)
39303	Бусад биет бус хөрөнгө	346,345,400.00	346,345,400.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>1,295,171,374.17</u></b>	<b><u>1,657,101,018.25</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>252,767.77</u></b>	<b><u>81,990.00</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	252,767.77	81,990.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	252,767.77	81,990.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	50,400.00
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	-	31,590.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	-	31,590.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>1,294,918,606.40</u></b>	<b><u>1,657,019,028.25</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	1,294,918,606.40	1,657,019,028.25
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	776,113,300.00	776,113,300.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	216,598,516.81	578,698,938.66
51210	Өмнөх үеийн үр дүн	195,539,361.05	216,598,516.81
51220	Тайлант үеийн үр дүн	21,059,155.76	362,100,421.85

51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	302,206,789.59	302,206,789.59
6	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>1,295,171,374.17</b>	<b>1,657,101,018.25</b>

## 2.2 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН /төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>425,157,656.00</b>	<b>882,738,092.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>67,918,602.00</b>	<b>445,123,074.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	67,918,602.00	445,123,074.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	67,918,602.00	445,123,074.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	605,000.00	605,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	67,313,602.00	444,518,074.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>357,239,054.00</b>	<b>437,615,018.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	19,940,054.00	87,140,518.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	19,940,054.00	87,140,518.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	337,299,000.00	350,474,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	308,931,400.00	332,884,500.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	28,367,600.00	17,590,000.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>403,319,168.04</b>	<b>520,637,670.15</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>403,319,168.04</b>	<b>520,637,670.15</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	382,016,371.94	508,585,274.10
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	181,502,630.00	216,654,387.96
210101	Үндсэн цалин	156,193,372.00	149,519,187.88
210102	Нэмэгдэл	25,309,258.00	34,574,329.33
210105	Гэрээт ажлын хөлс	-	32,560,870.75
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	22,898,123.92	28,553,152.46
210201	Тэтгэврийн даатгал	15,632,779.32	20,115,160.38
210202	Тэтгэмжийн даатгал	1,816,336.15	2,105,699.14
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,453,068.92	1,685,500.12
210204	Ажилгүйдлийн даатгал	363,267.23	423,497.04
210205	Эрүүл мэндийн даатгал	3,632,672.30	4,223,295.78
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	14,346,222.00	15,515,322.30
210301	Гэрэл, цахилгаан	3,280,722.00	3,808,262.30
210302	Түлш, халаалт	11,065,500.00	11,707,060.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	25,347,162.00	25,985,019.00
210401	Бичиг хэрэг	3,843,000.00	4,780,207.00
210402	Тээвэр, шатахуун	19,680,262.00	18,893,119.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,823,900.00	2,311,693.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	276,000.00	280,800.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	276,000.00	280,800.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	2,533,700.00	2,159,900.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	181,000.00	140,000.00
210604	Урсгал засвар	2,352,700.00	2,019,900.00

<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	4,763,000.00	1,412,000.00
210702	Дотоод албан томилолт	4,763,000.00	1,412,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	50,029,270.00	41,138,555.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	49,338,470.00	40,428,555.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	300,000.00	260,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	234,000.00	450,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	80,320,264.02	176,886,137.38
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	14,098,000.00	86,990,113.46
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	66,222,264.02	89,896,023.92
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	21,302,796.10	12,052,396.05
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	2,698,600.00	225,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	275,000.00	225,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	18,603,583.10	11,827,396.05
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	18,603,583.10	11,827,396.05
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	613.00	
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>21,838,487.96</b>	<b>362,100,421.85</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>21,059,155.76</b>	<b>362,100,421.85</b>

### 2.3 АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>357844054.00</b>	<b>438220018.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>605000.00</b>	<b>605000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	605000.00	605000.00
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	605000.00	605000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	605000.00	605000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>357239054.00</b>	<b>437615018.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	19940054.00	87140518.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	19940054.00	87140518.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	337299000.00	350474500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	308931400.00	332884500.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	28367600.00	17590000.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>340777554.00</b>	<b>354924318.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>340777554.00</b>	<b>354924318.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>319474757.90</b>	<b>342570658.95</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	181639686.90	217526987.96
210101	Үндсэн цалин	122738286.90	150091787.88
210102	Нэмэгдэл	27557400.00	34574329.33
210105	Гэрээт ажлын хөлс	31344000.00	32860870.75
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	22709708.00	28295433.69
210201	Тэтгэврийн даатгал	15449878.00	19857441.61
210202	Тэтгэмжийн даатгал	1768506.00	2105699.14

210203	ҮОМШӨ-ний даатгал	1498365.00	1685500.12
210204	Ажилгүйдлийн даатгал	343907.00	423497.04
210205	Эрүүл мэндийн даатгал	3649052.00	4223295.78
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>15546822.00</b>	<b>15480062.30</b>
210301	Гэрэл, цахилгаан	3544722.00	3808262.30
210302	Түлш, халаалт	12002100.00	11671800.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>21813784.00</b>	<b>21874010.00</b>
210401	Бичиг хэрэг	4199000.00	4199000.00
210402	Тээвэр, шатахуун	15516100.00	14782110.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2098684.00	2892900.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>399800.00</b>	<b>337800.00</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	399800.00	337800.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>3337700.00</b>	<b>2159900.00</b>
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	200000.00	140000.00
210604	Урсгал засвар	3137700.00	2019900.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>4763000.00</b>	<b>1412000.00</b>
210702	Дотоод албан томилолт	4763000.00	1412000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>51079257.00</b>	<b>40480965.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	50169457.00	39770965.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	260000.00	260000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	234000.00	450000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>18185000.00</b>	<b>15003500.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	18185000.00	15003500.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>21302796.10</b>	<b>12353659.05</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>2698600.00</b>	<b>225000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	275000.00	225000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>18603583.10</b>	<b>11827396.05</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	18603583.10	11827396.05
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>613.00</b>	<b>301263.00</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	613.00	301263.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>17066500.00</b>	<b>83295700.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>17066500.00</b>	<b>83295700.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>17066500.00</b>	<b>83295700.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>17066500.00</b>	<b>83295700.00</b>
220001	Барилга байгууламж		13365700.00
223001	Бусад хөрөнгө		69930000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>-17066500.00</b>	<b>-83295700.00</b>

## 2.4 АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	<b>2016 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	776,113,300.00	303,019,220.79	194,726,929.85	1,273,859,450.64
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			812,431.20	812,431.20
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>776,113,300.00</b>	<b>303,019,220.79</b>	<b>195,539,361.05</b>	1,274,671,881.84
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт		-812,431.20		-812,431.20
C07	Тайлант үеийн үр дүн			21,059,155.76	21,059,155.76
C08	<b>2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>776,113,300.00</b>	<b>302,206,789.59</b>	<b>216,598,516.81</b>	1,294,918,606.40
D01	<b>2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>776,113,300.00</b>	<b>302,206,789.59</b>	<b>216,598,516.81</b>	1,294,918,606.40
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>776,113,300.00</b>	<b>302,206,789.59</b>	<b>216,598,516.81</b>	1,294,918,606.40
D08	Тайлант үеийн үр дүн			362,100,421.85	362,100,421.85
D09	<b>2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>776,113,300.00</b>	<b>302,206,789.59</b>	<b>578,698,938.66</b>	1,657,019,028.25

## 2.5 АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	333897600.00	339252103.95
21	УРСГАЛ ЗАРДАЛ	320531900.00	325886403.95
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	320256900.00	325661403.95
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	224780300.00	217526987.96
210101	Үндсэн цалин	151350400.00	150091787.88
210102	Нэмэгдэл	37236200.00	34574329.33
210105	Гэрээт ажлын хөлс	36193700.00	32860870.75
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	30345800.00	28295433.69
210201	Тэтгэврийн даатгал	21354200.00	19857441.61
210202	Тэтгэмжийн даатгал	2247800.00	2105699.14
210203	ҮОМШӨ-ний даатгал	1798200.00	1685500.12
210204	Ажилгүйдлийн даатгал	450000.00	423497.04
210205	Эрүүл мэндийн даатгал	4495600.00	4223295.78
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	15490300.00	15480062.30
210301	Гэрэл, цахилгаан	3818100.00	3808262.30
210302	Түлш, халаалт	11672200.00	11671800.00
2104	Хангамж, бараа материалын зардал	21874800.00	21874010.00
210401	Бичиг хэрэг	4199000.00	4199000.00
210402	Тээвэр, шатахуун	14782900.00	14782110.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2892900.00	2892900.00
2105	Нормативт зардал	337800.00	337800.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	337800.00	337800.00

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2882500.00	2159900.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	168000.00	140000.00
210604	Урсгал засвар	2714500.00	2019900.00
2107	Томилолт, зочны зардал	2229600.00	1412000.00
210702	Дотоод албан томилолт	2229600.00	1412000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7259500.00	23571710.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6121000.00	22861710.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	260000.00	260000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	450000.00	450000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	15056300.00	15003500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	15056300.00	15003500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	275000.00	225000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	275000.00	225000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	275000.00	225000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	13365700.0	13365700.0
2200	Дотоод эх үүсвэрээр	13365700.0	13365700.0
220001	Барилга байгууламж	13365700.00	13365700.00
13	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	351487600.00	339252103.95
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	350882600.00	338647103.95
132001	Орон нутгийн төсвөөс	333292600.00	321057103.95
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	17590000.00	17590000.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	605000.00	605000.00
120004 1	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	605000.00	605000.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	27.00	23.00
620001	Удирдах ажилтан	8.00	8.00
620002	Гүйцэтгэх ажилтан	8.00	7.00
620003	Үйлчлэх ажилтан	3.00	3.00
620004	Гэрээт ажилтан	8.00	5.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	27.0	23.0
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	7.00	6.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	5.00	5.00
650010	Гэрээт ажилтан	8.00	5.00
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	7.00	7.00

## 2.6 АУДИТ ХИЙСЭН НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН /төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>19921441.00</b>	<b>87140518.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>19921441.00</b>	<b>17210518.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	19921441.00	17210518.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	17879257.00	17210518.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	17879257.00	17210518.00
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>613.00</b>	<b>301263.00</b>
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	613.00	301263.00

<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>0.00</b>	<b>69930000.00</b>
2200	Дотоод эх үүсвэрээр	0.00	69930000.00
223001	Бусад хөрөнгө		69930000.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	19940054.00	87140518.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	19940054.00	87140518.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	19940054.00	87140518.00

### 3.АУДИТЫН ТАЙЛАН

#### 3.1. Ерөнхий зүйл

2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Засаг даргын Тамгын газрын дарга Ш.Даваатогтох танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд удирдах, хяналт тавих шинжтэй ажил хавсран гүйцэтгэж байгаа, нярав бараа материалын тайлан гаргаагүй зэрэг алдаа зөрчлүүдэд зөвлөмж өгч менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 02 дугаар сарын 19-ноос 2021 оны 02 дугаар сарын 20-ны хооронд Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Д.Балжинням хариуцаж хэрэгжүүлэв.

#### 3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

аймгийн Цагдаагийн газар нь Монгол Улсын Үндсэн хууль, Цагдаагийн албаны тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж, дээд шатны байгууллага, албан тушаалтны тогтоол, шийдвэр, тэдгээрийг хэрэгжүүлэхтэй холбоотой хөтөлбөр, төлөвлөгөө, хуулиар хүлээсэн үндсэн чиг үүргийн хүрээнд Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагаас 2020 онд дэвшүүлсэн зорилт, гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган үр дүнг тооцон ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлт
- Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолоор “Төрийн албан хаагчийн цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай”
- Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 183 тоот “бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай”
- Засгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 10 тоот “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай

#### 3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Засаг даргын Тамгын газрын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Засаг даргын Тамгын газрын 2020 онд тус байгууллагад дотоод хяналт хийгдээгүй аймгийн төрийн сангаас өдөр тутмын гүйлгээнд хяналт хэрэгжүүлсэн байна.

Мөн тухайн байгууллага дотоод аудитын нэгжгүй, хяналт хэрэгжүүлсэн талаар ажлын тайлан ирүүлээгүй болно.

Байгууллагын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд Дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

### 3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, эрсдэлийн түвшнийг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт орлогоос 780612.9 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 7806.1 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсон.

Харин гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт орлогоос 882738.0 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 8827.3 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцлоо.

### 3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Засаг даргын Тамгын газрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос мянган төгрөгөөр буюу 1.2 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
АВЛАГА	572.0	0.0	0.0
БАРАА МАТЕРИАЛ	17441.0	17206.0	(235.0)
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1277154.6	1569663.7	292509.1
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1295171.4</b>	<b>1586869.8</b>	<b>291698.4</b>
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	257.7	81.99	(175.8)
ЗАСГИЙН ГАЗРЫН ОРОЛЦОО	776113.3	776113.3	0.0
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1294918.6	1586787.7	291869.1
<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1295171.4</b>	<b>1586869.8</b>	<b>291698.4</b>

Авлага дансны үлдэгдэл 572.0 мянган төгрөг байснаас 572.0 мянган төгрөгөөр буурч, оны эцсийн үлдэгдэл 0.0 мянган төгрөг болсон. Тайланд онд шинээр авлага үүсээгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 17206,0 мянган төгрөг болж 235.0 мянган төгрөгөөр буурсан байна. Буурсан дүнд нөлөөлж байгаа зардал нь мал амьтан дээр байсан 1000.0 мянган төгрөгийн бараа материалыг байгууллагын даргын тушаалаар акталсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл оны эхэнд 1834963.2 мянган төгрөг, оны эцэст 2196640.3 мянган төгрөг болж 361677.1 мянган төгрөгөөр өссөн байна.

Үндсэн хөрөнгийн төсвийн хөрөнгөөр 13365,7 мянган төгрөг, улсын төсвөөс бетон гүүр 349888.9 мянган төгрөг, орон нутгийн хөгжлийн сангаас хашаа 54586.9 мянган төгрөг нийт 425990.9 мянган төгрөгөөр нэмэгдэж, мал эмнэлгийн газарт 20150,0 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл, машин тоног төхөөрөмж шилжүүлсэн байна.

Засаг даргын Тамгын газрын 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 457580.4 мянган төгрөгөөр буюу 2 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь үйл ажиллагааны санхүүжилт 339252.1 мянган төгрөг болж өмнөх оноос 12235.4 мянган төгрөгөөр өссөн, 337204.4 мянган төгрөгөөр үнэ төлбөргүй орлого нэмэгдсэн ,орон нутгийн хөрөнгө оруулалтаас 67200.4 мянган төгрөгийн санхүүжилтэй холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 520938.9 мянган төгрөг болж өмнөх үеийнхээс 117619.7 мянган төгрөг буюу 29.2 хувиар өссөн нь өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин, шимтгэлийн зардал 40806.8 мянган төгрөг буюу 19.9 хувиар, тогтмол зардал 1169.1 мянган төгрөг буюу 8.1 хувиар, хангамж бараа материалын зардал 637.8 мянган төгрөг буюу 2.5 хувиар, нормативд зардал 4.8 мянган төгрөг буюу 1.7 өссөн, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж 8890.7 мянган төгрөг буюу 17.7 хувиар буурсан, эд хогшил, урсгал засварын зардал 373.8 мянган төгрөг буюу 14.7 хувиар буурсан, томилолтын зардал 3351.0 мянган төгрөг буюу 70.3 хувиар буурсан, бараа үйлчилгээний бусад зардал 96565.8 мянган төгрөг буюу 120.2 хувиар өссөн, нэг удаагийн тэтгэмж шагнал урамшууллын зардал 2473.6 мянган төгрөг буюу 91.6 хувиар буурсан байна.

### 3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### Төсвийн төлөвлөлт:

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 351079.5 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 351079.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

#### Төсвийн гүйцэтгэл:

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 351079.5 мянган төгрөгийн төсөв баталснаас 350474.5 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 605.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 350474.5 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлого 605.0 мянган төгрөг, нийт 351079.5 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 339252.2 мянган төгрөгийг зарцуулж 11827.3 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 339252.2 төгрөг буюу 96.6 хувьтай байгаа нь цалин хөлс нэмэгдэл урамшуулал, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд 217526.9 мянган төгрөг, тогтмол зардалд 15480.0 мянган төгрөг, хангамж бараа материалын зардалд 21874.0 мянган төгрөг, нормативд зардалд 337.8 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөрт 23270.4 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 15003.5, хөрөнгийн зардалд 13365.7 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Хүснэгт 3	Хөтөлбөр, арга хэмжээний хэмнэлт	/мян.төг/
код	хөтөлбөр, арга хэмжээ	мөнгөн дүн
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	5700.4
80103	Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил ,үйлчилгээ	1331,2

80106	Баг,хорооны зардал	4416,4
80205	Мэдээлэл,сурталчилгааны зардал	60,0
82212	Хур хог хаягдал,орчны бохирдол	142,8
81701	Байгаль орчныг хамгаалах,нөхөн сэргээх	16,5
80103	Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил,үйлчилгээ	160,0
<b>ДҮН</b>		<b>11827.3</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

### Нэмэлт санхүүжилт:

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд 87140.5 мянган төгрөг төвлөрснөөс Орон нутгийн хөрөнгө оруулалтаар 69930.0 мянган төгрөг, Засаг даргын захирамжаар ЗДТГ-аас 13014.2 мянган төгрөг, Онцгой байдлын газраас 180,0 мянган төгрөгийг тус тус орж батлагдсан арга хэмжээний зардалд зарцуулж. 301.2 мянган төгрөгийг татан төвлөрүүлсэн байна.

### 3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Буянт сумын Тамгын газар нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг хуулийн хугацаанд нь мэдээлсэн байна.

### 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 29200.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 3 зөвлөмж өгөгдөж, төлбөрийн акт, зөвлөмжийн хэрэгжилт 75 хувьтай байна. Төлбөрийн акт биелэгдэхгүй байгаа шалтгаан нь тухайн аж ахуйн нэгж шүүхийн байгууллагад хандсантай холбоотой байна.

Хүснэгт 4: Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт /мянган.төг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	3200.0	0.0	0.0	1	3200.0	
Албан шаардлага		0,0		0,0	-	-	
Зөвлөмж	3	26000.0	3	26000.0			100%
Нийт дүн	4	29200.0	3	26000.0	1	3200.0	75%

### 3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 63895.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 63400.0 мянган төгрөгийн алдааг залруулж, 0.0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

**Залруулсан алдаа:** Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

**Цалин хөлс бүтэц орон тоотой холбоотой.**

**1.1. Илрүүлэлт:** СТА-ын завсрын аудитаар тайлант оны 10 дугаар сарын байдлаар цалингийн сангаас 14.0 сая төгрөг хэмнэгдэж байгаа нь САД, МАА, гэрээт гэсэн 3 орон тоонд дээр хүн ажиллаагүйгээс 8.8 сая, үндсэн ажилчдын цалин хөлснөөс 5.7 сая төгрөгийн хэмнэлт үүсэж байна. Цалин хөлстэй холбоотой хэмнэлтийн шалтгаанаас эрсдэл үүсгэн хянаж үзэхэд нийт ажилтан албан хаагч нарт үр дүнгийн урамшууллыг ТЖАХ ажлыг дүгнэж улирал бүр олгоогүй, 1 удаа олгоходоо хавтгайруулан 45% олгосон, ТҮ албан хаагч нарт ур чадварын нэмэгдэл олгодоггүй, нийт албан хаагч нарт унаа хоолны хөнгөлөлт үзүүлдэггүй, ажил хавсарсны нэмэгдэл олгоогүй зэрэг зөрчил дутагдал илэрлээ.

**1.2 Эрсдэл:** Дээрх алдаа зөрчил нь Төрийн албаны тухай хууль 57.2.4.үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн хувьд албан тушаалын цалин болон докторын, мэргэшлийн зэрэг, цол, ур чадварын, төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл болон бусад нэмэгдэл, нэмэгдэл хөлснөөс тус тус бүрдэнэ. Засгийн газрын 2018 оны 382 тогтоолын 4 хавсралт Төрийн үйлчилгээний байгууллагын удирдах, гүйцэтгэх, туслах албан хаагчид төрийн үйлчилгээний албан тушаал эрхэлж байх хугацаанд нь ур чадварын нэмэгдэл олгох асуудлыг энэ журмын 4-т заасан шалгуур үзүүлэлтийн дагуу албан тушаалын сарын үндсэн цалингаас 10-25 хувиар тооцож, сар бүр олгоно. Засгийн газрын 2019 оны 5 тогтоол 3 хавсралт 1.3. Улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгоход шаардагдах хөрөнгийг төсвийн байгууллага жил бүр төсөвтөө тусгана. 2.2. Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 40 хувиас хэтрэхгүй байна. Хөдөлмөрийн тухай хуулийн 18 зүйл Ажилтанд олгох хоол, унааны зардал болон бусад нөхөх олговрын хэмжээг тогтоох, Засгийн газрын 2019 оны 6 тогтоолын хавсралт 8 бусад нөхөн олговор 8.4 ТАХ өдрийн хоолны зардлын тодорхой хэсгийг байгууллагаас нөхөн олгоно гэсэнтэй нийцэхгүй байна.

**1.3. Шийдвэрлэсэн нь:** Тайлант хугацаанд байгууллагын дотоод журамд өөрчлөлт оруулан ажилчдад өдрийн хоолны зардлыг нөхөн олгосон, үр дүнгийн мөнгөн урамшууллыг ажлын гүйцэтгэлээр олгосон, Төрийн үйлчилгээний гүйцэтгэх, туслах албан хаагчид төрийн үйлчилгээний албан тушаал эрхэлж байх хугацаанд нь ур чадварын нэмэгдэл олгож алдаа зөрчлийг залруулсан байна. Батлагдсан орон тоон дээр хүн ажиллаагүйтэй холбоотой хэмнэгдсэн зардлыг татан төвлөрүүлсэн байна.

### **Тайлант оны зардалтай холбоотой.**

**2.1 Илрүүлэлт:** Засаг даргын Тамгын газрын нэмэлт дансаар орон нутгийн хөрөнгө оруулалтаар Шаргуугийн услалтын системийн толгойн барилгын ажлын 69930.0 мянган төгрөгийн зардлыг ажил нь дуусаагүй байгаа тул дуусаагүй үйлдвэрлэл дансанд бүртгүүлж залруулга хийсэн болно.

**Шийдвэрлэсэн нь:** Байгууллагын удирдлага, нягтлан бодогч нарт асуудлын бүртгэлээр танилцуулан 83930.0 мянган төгрөгийн залруулга хийж, залруулсан албан тоот ирүүлсэн болно.

### **Аудитын зөвлөмж**

Аудитаар илэрсэн алдаа, зөрчилд 2 зөвлөмж өгч менежментийн захидалд тусгав.

## **3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД**

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татсан асуудал байхгүй байна.

#### 4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

##### **Батлагдсан орон тоотой холбоотой асуудал**

**1.1 Илрүүлэлт:** Буянт сумын ЗДТГ нь тайлант онд үндсэн 14, гэрээт 4 нийт 18 орон тоотойгоор ажиллахаас тайлант онд САД-ын, МАА асуудал хариуцсан орон тооны ажилтан, сумын хог хаягдал цэвэрлэх гэрээт ажилтан ажиллуулаагүйтэй холбоотой тухайн албан тушаалтны ажлын байрны тодорхойлолтод заагдсан төрийн үйлчилгээний ажлуудыг цалгардуулж байгаа, мөн эзгүй байгаа САД-ын албан тушаалыг Төрийн сангийн төлбөр тооцооны мэргэжилтэн хавсран гүйцэтгэж байгаа зөрчил дутагдал илэрлээ.

**1.2 Эрсдэл:** Хуулийн хэрэгжилт хангагдахгүй байх, дотоод хяналт хэрэгжүүлээгүй байх

**1.3 Өгсөн зөвлөмж** Хөдөлмөрийн тухай хууль 28 дугаар зүйл. Хэд хэдэн ажил олгогчид нэгэн зэрэг ажиллахыг хориглох 28.1. "Хуулийн этгээдэд эд хөрөнгө захиран зарцуулах эрх мэдэл хэрэгжүүлэх ажил, албан тушаалд ажилладаг ажилтан адил төрлийн үйл ажиллагаа явуулдаг өмчийн бусад төрөл, хэлбэрийн өмчлөгчтэй эрхэлж байгаа ажил, албан тушаалтайгаа ижил, эсхүл удирдах, хяналт тавих шинжтэй ажил, албан тушаалд ажиллахаар зэрэгцсэн гэрээ буюу контракт байгуулахыг хориглоно" Төрийн албаны тухай хууль 43.3.4.жирэмсний болон амаржсаны амралттай, хүүхэд асрах чөлөөтэй, түүнчлэн эрүүл мэндийн шалтгааны улмаас 3 сараас 1 жил хүртэл хугацаагаар эмчлүүлж, сувилуулах шаардлагатай болсон тохиолдолд албан тушаалын чиг үүрэг нь хамгийн ойр хамааралтай албан хаагчаар, эсхүл төрийн албан хаагчийн нөөцөд бүртгэгдсэн иргэнийг сонгон авч, тодорхой хугацаагаар түр орлон гүйцэтгүүлэх. 2.1. Төрийн албаны тухай хуулийн 42.1-д заасан үндэслэлээр эзгүй байгаа албан хаагчийн албан үүргийг 2-6 сар хүртэл хугацаагаар түр орлон гүйцэтгэсэн төрийн жинхэнэ албан хаагчид цалингийн зөрүүг олгоно гэснийг мөрдөж ажиллах. Батдагдсан орон тооны ажлын байрны тодорхойлолтод нийцсэн албан тушаалтныг яаралтай авч ажиллуулах.

**1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Хүлээн зөвшөөрсөн.

##### **Бараа материалын тайлан гаргалттай холбоотой**

**2.1. Илрүүлэлт:** Тайлант хугацааны бараа материалын тайланг нярав Цэнд-Аюуш ажлын байрны тодорхойлолтод заасан байгууллагын эд хогшил үндсэн ба эргэлтийн хөрөнгөд зохих журмын дагуу бүртгэл хөтлөн, хадгалалт хамгаалалтад хяналт тавих үүрэгт ажлаа хангалтгүй биелүүлж бараа материалын тайлан гаргаагүй зөрчил дутагдал илэрлээ.

**2.2. Эрсдэл:** Байгууллагын аж ахуйн болон мөнгөн хөрөнгийн өдөр тутмын үйл ажиллагаа доголдох, эд хөрөнгийн хадгалалт хамгаалалт тавих хяналт сулрах.

**2.3. Өгсөн зөвлөмж:** Хариуцсан ажлаа цаг хугацаанд нь чанартай хийж гүйцэтгэн бараа материалын тайланг гаргаж хэвших.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТ

Огноо:	Аудитын нэр:	<b>Ховд аймгийн Буянт сумын ЗДТГ-ын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит</b>	Аудитын код:
2021			ХОА-2021/151/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	<b>Буянт сумын Засаг даргын Тамгын газар</b>		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
1	2	3	4	5	6
1	<i>Тайлант хугацаанд байгууллагын дотоод журамд өөрчлөлт оруулан ажилчдад өдрийн хоолны зардлыг нөхөн олгосон, үр дүнгийн мөнгөн урамшууллыг ажлын гүйцэтгэлээр олгосон, Төрийн үйлчилгээний гүйцэтгэх, туслах албан хаагчид төрийн үйлчилгээний албан тушаал эрхэлж байх хугацаанд нь ур чадварын нэмэгдэл олгож алдаа зөрчлийг залруулсан байна. Батлагдсан орон тоон дээр хүн ажиллаагүйтэй холбоотой хэмнэгдсэн зардлыг татан төвлөрүүлсэн байна</i>	14000.0	Залруулга хийх		
2	<i>Засаг даргын Тамгын газрын нэмэлт дансаар орон нутгийн хөрөнгө оруулалтаар Шаргуугийн услалтын системийн толгойн барилгын ажлын 69930.0 мянган төгрөг, шинээр худаг гаргахад 13014.2 мянган төгрөг нийт 82371 мянган төгрөгийн зардлыг ажил нь дуусаагүй байгаа тул дуусаагүй үйлдвэрлэл дансанд бүртгүүлж залруулга хийсэн болно.</i>	82371.0	Залруулга хийх	Дарга , нягтлан бодогч	Ш.Даваатогтох Д.Болортуяа
3	<i>Тайлант хугацааны бараа материалын тайланг нярав Цэнд-Аюуш ажлын байрны тодорхойлолтод заасан байгууллагын эд хогшил үндсэн ба эргэлтийн хөрөнгөд зохих журмын дагуу бүртгэл хөтлөн, хадгалалт хамгаалалтад хяналт тавих үүрэгт ажлаа хангалтгүй биелүүлж бараа материалын тайлан гаргаагүй зөрчил дутагдал илэрлээ.</i>	0	Зөвлөмж		
4	<i>Батдагдсан орон тооны ажлын байрны тодорхойлолтод нийцсэн албан тушаалтныг яаралтай авч ажиллуулах.</i>	0.0	Зөвлөмж		
<b>ДҮН</b>		<b>96371.0</b>			

### ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

